

Төв Азийн нүүдэлчдийн дунд угсаа-соёлын
бүслэл тогтсон нь

Докторант П.Дэлгэржаргал

Монгол нутагт нүүдлийн МАА үүсэн, нүүдэлчин овог аймгууд бий болж, нүүдлийн иргэншил бүрэлдэн төлөвшсөн үйл явц болон эртний нүүдэлчдийн дотор угсаа соёлын бүслэл тогтон, анхны төрийн бүрдлүүд үүсэн хөгжсөн зэрэг асуудлуудыг нарийвчлан судлах нь Монголын түүхийн шинжлэх ухааны өмнө тулгамдсан асуудал болон тавигдаж байна.

Евроазийн хээр тал нутагт нүүдлийн иргэншил үүсэн төлөвшсөн асуудлыг тодруулахын тулд юуны өмнө нүүдлийн МАА-н хөгжлийн явц, нүүдэлчдийн овгийн зохион байгуулалтын өвөрмөц онцлог, түүнд суурилсан нийгмийн харилцааны хувьсал хөгжлийг хамтад нь улируулан судлах шаардлагатай. Неолитийн хувьсгал гэж нэрлэгдсэн үйлдвэрлэх аж ахуй /МАА, газар тари/ үүсэх үйл явц Евроазийн төвүүдийн нэгэн адил Монгол нутагт явагдсан / 2/ төдийгүй Монгол орон бол МАА үүссэн анхны голомт нутгуудын нэг мөн. Сүүлийн үед зарим судлаачид Монгол нутагт мезолитын үед мал аж ахуй үүссэн хэмээн үзэж байна./11.86/ Неолитын үед газар тариалан, мал аж ахуй, ан агнуур, загасчлал зэрэг аж ахуйн бүрэн цогцолбор бүрэлджээ./ 5.12/ Эрс тэс хуурай уур амьсгалтай Монгол нутагт газар тариалан, суурин мал аж ахуй эрчимтэй хөгжих нөхцөл боломж хаязгаарлагдмал байснаас нутгийн өвөрмөц байгаль цаг уурт зохицсон мал бий болгох улмаар арчлах, өсгөн үржүүлэх, хариулан маллах арга туршлага хуримтлагдан сайжирсны үр дүнд бэлчээрийн мал аж ахуй давамгайлан хөгжих болжээ.

Эх газрын эрс тэс уур амьсгалтай, хээр талын хатуу хөртэй, хур тунадас багатай Төв Азийн экологийн орчинд идээшин амьдрахдаа Монголчуудын өвөг эдэдэс байгаль газар зүйн нөхцөлдөө хамгийн тохиромжтой бэлчээрийн мал аж ахуйн арга технологийг үүсгэн хөгжүүлж, сонгомол нүүдлийн иргэншлийг бүрэлдэн төлөвшүүлжээ.

Хүрлийн үеэс МАА-н үйлдвэрлэл нарийсч, мэргэжлийн шинжтэй болж, нүүдлийн МАА үүсэн, эл мал аж ахуйг дагнан эрхэлдэг нүүдэлч малчин овог аймгууд бий болсон нь тэдний ахуй, соёл, оюун санаанд ихээхэн өөрчлөлт оруулжээ. Адууг уналга тээвэрт хэрэглэх болсон нь мал сүргийг хариулан маллах, ан агнах, алс хол нүүдэллэн явж бусад аймгуудтай харилцан, арилжаа наймаа хийх зэргээр нүүдэлчдийн нийгэм эдийн засагт ахиц дэвшил гаргахад хүргэжээ. / 7.64-65., 11.136-137/ Энэ үеийн археологийн соёлд шинэ зүйлүүд үлэмж гарч ирж, хэлбэр агуулга нь баяжиж, өвөрмөц онцлог бүхий угсаа соёлын бүслэлүүд бий болсон явдал болон Хятад сурвалжийн мэдээнүүд үүнийг нотолж байна.

Судлаачид нүүдлийн мал аж ахуй үүсэж, нүүдэлчин овог аймгууд бий болсныг МЭӨ II мянганы II хагасад холбогдуулан үздэг./11.134/ Хүрлийн үед Монгол нутагт нүүдлийн мал аж ахуй эрчимтэй хөгжсөнийг археологийн олдворууд нотолж байна. Мал аж ахуйн хөгжлийг гэрчлэх нэг баримт бол манай нутгаас олдож буй хазаар, зуузай, шахуурга, бөгж, оломны арал, янз бүрийн хүрэл даруулга зэрэг тоног хэрэгсэл, морь малд хөллөсөн тэрэг, анжисны зураг зэрэг юм. Мөн түүнчлэн чинжаал хутганы хуйг модоор хийж, гадуур нь давхар ширлэсэн байхаас гадна сураар морь малын тоног хэрэгсэлийг зангидаж, суран эдлэлийг шөрмөсөөр үдэж, оёж, сумны зэвийг мөсөнд суулгаад шөрмөсөөр давхар бэхэлсэн зэрэг малын арьс, ширийг элдэж боловсруулан оёж үдэх, зангидах, наах олон аргыг хэрэглэн хэрэгцээний зүйлээ хийдэг байжээ. /11.136-137/

Өнөөгийн судалгааны түвшинд хүрлийн үеийн хиригсүүр, дөрвөлжин булшнаас олддог малын яс, мал аж ахуйтай холбогдох тоног хэрэгсэл, урлагийн дурсгалууд болон мөн үеийн хадны сүг зургууд зэрэг хэрэглэгдэхүүнд тулгуурлан нүүдлийн мал аж ахуй үүссэн он цагийг тогтоож байна. Өөрөөр хэлбэл, судлаачид дөрвөлжин булшийг МЭӨ XIII-III зуунд, хиригсүүрийг МЭӨ II мянганы дунд үеэс МЭӨ I мянгантай холбогдуулж

байгаа нь ийм дүгнэлт хийх гол үндэслэл юм. Гэтэл дээрх дүгнэлт нь тухайн үеийн Төв Азийн нүүдэлчдийн хөгжлийн түвшин, хятад сурвалжийн зарим мэдээнүүдтэй зөрчилдөж байна. Тухайлбал, МЭӨ II мянганы II хагас гэхэд Төв Азийн нүүдэлчдийн орон нутгийн түгжигдмэл явцуу байдал эвдэгдэн, аж ахуй, соёлын харилцаа холбоо ихээхэн тэлж, угсаа соёлын бүслэл нэгэнт тогтсон байв.

Хүрэл, төмрийн үед дорнод Монголд монгол төрхийн Төв Азийн антропологийн хэв шинжтэй хүн ам, баруун Монголд Алтай Тува орчимд түүхэн мөн үед иргэншиж байсан европ монгол төрхтний завсрын хэв шинжийн онцлогтой хүн амтай нэлээд ойролцоо хүн ам иргэншиж байсныг Монгол төрхийн хүн ам баруун тийш аажмаар нүүдэллэн суурьшиж, уугуул Европ төрхтөн хүн амтай холилдон амьдарч, тэдгээрийн хооронд цус холилдох үйл явц эрчимтэй явагдах болсонтой холбоотой хэмээн доктор Д.Түмэн үзжээ. /8. 49-50/

Харин археологийн сүүлийн үеийн судалгаагаар хүрлийн үед Монголын баруун нутагт хиригсүүрийн соёлыг үлдээгч овог аймгууд, дорнод Монголд дөрвөлжин булшны соёлыг үлдээгч овог аймгууд төвлөрөн оршиж байсан нь нотлогдож байна./11.93-106., 13.140-141/ Археологич Д.Эрдэнэбаатар МЭӨ III мянган жилийн сүүлээс эхэлсэн эртний нүүдэлчин овог аймгуудын шилжилт хөдөлгөөний өрнөлийн нөлөөнд хиригсүүрийн соёлыг үлдээгч овог аймгууд, буган чулуун хөшөөг үлдээгч аймгуудтай Алтайн нурууны бүс нутагт нэгдэн нийлж, одоогийн Монгол орны төв нутаг руу шилжих хөдөлгөөн эхэлж, МЭӨ II мянган жилийн эхэнд дөрвөлжин булшны соёлыг үлдээгч овог аймгуудтай одоогийн Төв монголын нутаг Хангай, Соёны салбар уулсын бүсэд учирсан хэмээн үзжээ. /13.146/

Дөрвөлжин булшны холбогдох он цаг судалгааны явцад улам бүр цаашилж байгаа бөгөөд энэхүү он цаг нь өөрчлөгдөж болохыг зарим эрдэмтэд хүлээн зөвшөөрч байгаа билээ. Монгол нутаг дахь хиригсүүрийн судалгаа нь зөвхөн эхлэлийн шатандаа байгаа учир ул суурьтай дүгнэлт хийх археологийн болон антропологийн хэрэглэгдэхүүн хараахан бүрдээгүй байна. Дөрвөлжин булшны өнөөгийн судалгаа нь холбогдох он цаг, орон зайн эзлэх хүрээг эцэслэн тогтоосон зүйл биш бөгөөд цаашдын судалгааны явцад нааш цаашаа хэлбэлзэн, холбогдох он цаг нь өөрчлөгдөх хандлагатай байна. /13.144-145/

Хятад сурвалжийн мэдээнүүд ч МЭӨ II мянганы II хагас гэхэд умар зүгийн нүүдэлчид нэлээд хүчирхэг, зохион байгуулалт сайтай байсныг нотолж байна.

Шар мөрнөөс Байгаль нуур хүртэлх Төв Азийн өргөн уудам хээр талд малжин амьдардаг нүүдэлчдийг эрт үедээ Гүйфан, Жун, Ди гэх зэргээр нэрлэн Хятад сурвалжид тэмдэглэжээ. Хэдийгээр үржил шимтэй газар нутаг эзлэн авах, бусад овог аймгуудыг өөртөө нэгтгэхийн төлөө хоорондоо өрсөлдөн тэмцэлдэж байсан ч нүүдэлчдийн нийтийн дайсан нь Хятадын нутагт тогтсон төр улсууд байв. Тэд нүүдэлчдийг умар зүг шахаж, Шар мөрөн, Хатан голын сав газар, Ордос зэрэг үржил шимтэй тариалан эрхэлж болох газар нутгийг нүүдэлчдээс булаан авахыг байнга санаархаж үе үе ихээхэн хэмжээний цэргийн хүчээр довтолдог байв. Нүүдэлчид ч мөчөөгөө өгөхгүй уулгалан довтолж, дээрэм тонуул хийдэг байжээ. Нүүдэлчид ба Хятадын эртний улсуудын хооронд болж байсан дайн байлдааны талаар Хятад сурвалжуудад нэлээд тодорхой тэмдэглэн үлдээжээ. Тухайлбал, Шан улсын /МЭӨ XVI-XI зуун/ У дин хаан Гүйфанчуудтай байлдсан тухай Хятад сурвалжуудад “У дин хааны 34-р он /МЭӨ 1221 он/-д хаан Гүйфан нарыг ялав”, “У дин хаан Гүйфанчуудтай дайтаж, 3 жил байлдан сая ялав” гэх зэргээр тэмдэглэн үлдээжээ. У дин хааны цэргийн жанжин нар болон У дин хаан өөрийн биеэр цэргээ удирдан Гүйфанчуудтай хэдэн жил дайтан байж ялалт байгуулснаас үзэхэд энэ үед Гүйфанчууд нь нэлээд хүчирхэг байсан нь харагдаж байна./4.16/ Түүнчлэн Ся угсааныхан /барагцаалбал МЭӨ XXI-XVI зуун/ унасны дараа Сягийн ноёрхогчдын доторх нэг бүлэг хүмүүс зугатан гарч, умар зүг хуньюйгийн нутагт дутаан хүрээд тэдний хамгаалалтанд оржээ. Шан угсааныхан Хуньюйгийн харьяанд орсон Ся угсааныхныг нэхэн цохилт өгсөнгүйгээс үзэхэд Хуньюйчүүдээс эмээсэн бололтой. Энэ тухай “Түүхэн тэмдэглэл”-ийн Хүннүгийн шастирт “Зе Ке үхсэнд түүний хүү Шун Вэ түүний олон татвар

эмийг гэргий болгон авч, умар зүг дутаан нүүдэллэн малжаад, Хуньюй хэмээн нэрийдэв" гэжээ. Сурвалжийн энэ мэдээ нь бусад угсаатныг Хятадын хаадаас гаралтай болгон бичдэг Хятадын түүх бичлэгийн уламжлалтай холбоотой ч Хятадын анхны төр Сягийн үед Хуньюй /хожмын Хүннү/ хэмээх нэлээд хүчирхэг аймаг оршин тогтнож, Ся улстай харилцаж байсныг гэрчилж байна. /4. 18/

Археологи, антропологийн судалгааны зарим үр дүн болон хятад сурвалжийн мэдээнд тулгуурлан наанадаж МЭӨ III мянганы сүүлчээр бэлчээрийн нүүдлийн мал аж ахуй үүсч, улмаар бэлчээрийн мал аж ахуйг эрхэлдэг нүүдэлчин овог аймгууд бий болсон гэж үзэж болохоор байна. Учир нь нүүдлийн мал аж ахуй үүссэнээр түүнд суурилсан нүүдлийн соёл иргэншил үүсэн төлөвшиж, улмаар Төв Азийн нүүдэлчдийн дунд угсаа-соёлын соёл иргэншил тогтсон /4.14/ хэмээн бид үзэж байна. Бэлчээрийн эрэл хайгуул, шинэ газар эзэмших явцад хиригсүүр, буган хөшөө болон дөрвөлжин булшны соёлыг үлдээгч нүүдэлчин овог аймгууд одоогийн төв монголын нутагт нэгэн үе зэрэгцэн оршиж, улмаар холилдон уусч, аж ахуй, соёл, хүн ам зүйн хувьд хоорондоо ихээхэн нөлөөлөлцжээ.

Нөгөө талаар нүүдлийн мал аж ахуй хөгжин, нүүдэлчин аймгууд бий болсон нь тэдний нийгмийн хөгжлийг эрс түргэсгэж, овгийн байгууллын задралыг хурдасган, төр төстэй бүрдлүүд үүсэх үндсэн нөхцлийг бүрдүүлжээ. Үнэхээр МЭӨ II мянганы үед Төв Азийн нүүдэлчдийн дотор нийгмийн ялгарал хүчтэй явагдаж байсныг археологийн дурсгалууд нотолж байна. Тухайлбал, сүүлийн үед ихэнх судлаачид МЭӨ II мянганд холбогдуулан үзэж байгаа буган хөшөө нь үүний тодорхой илэрхийлэл юм. Нэг дор хэдэн арваар нь босгосон буган хөшөө, нүсэр том хиригсүүр, дөрвөлжин булш, дагалдах олон байгууламжууд, ёслолын хэдэн арван цагираг зэрэг жирийн хүмүүст зориулан босгох боломжгүй хэдэн овог аймгийн хүчээр босгох нүсэр байгууламжуудыг овог аймгийн сурвалжитнууд, цэргийн жанжин нарын дурсгалд зориулан босгодог байсан нь үүнийг баталж байна.

Нүүдэлчин овог аймгуудын цэрэг эрс чинжаал, хутга, байлдааны зээтүү, илд, жад, бороохой, энгийн болон зүймэл нум сум зэргээс гадна бамбай, дуулга зэрэг хамгаалах зэвсэг өмсгөлтэй байсан төдийгүй зэвсэглэлийн чанараараа довтолгооны ба хориглолтын, хүнд ба хөнгөн морин цэрэг хэмээн ялгарах цэргийн төрөл нэгэнт бий болсон байжээ./13. 68-76/. Энэ бүхэн Монгол нутагт оршин байсан хүрлийн үеийн нүүдэлчдийн нийгмийн хөгжил нэлээд өндөр түвшинд хүрснийг илтгэн харуулаад зогсохгүй тэдний аж ахуйн хөгжлийн ерөнхий дүр зургийг ч мөн нэгэн адил тодорхой харуулж байна.

Хүннү нарын антропологийн хэв шинж бүрэлдэх үйл явцад дорнод монголын хүрлийн үеийн дөрвөлжин булшийн соёлт хүн ам, баруун монголын хиригсүүр буюу чулуун овоот булшийн соёлт хүн ам гол цөм нь болсон гэж үзэж болох юм. Харьцуулсан судалгаанаас үзэхэд орчин үеийн Монголчууд нь төв монголын хүрлийн үеийн дөрвөлжин булшны соёл, хүннү, дундад зууны түрүү үе, монголын үеийн хүн амтай угсаа гарвалын нягт холбоотой болох нь харагдаж байна. /10.51/

Дүгнэлт

Дөрвөлжин булшны олдворууд, хадны сүг зургууд зэргээс үзэхэд МЭӨ II мянганы II хагас гэхэд нүүдлийн МАА-н хөгжил нэлээд хөгжингүй шатанд хүрсэн нь харагдаж байна. Нүүдлийн мал аж ахуй үүсэн, эл аж ахуйг дагнан эрхэлдэг нүүдэлчин овог, аймгууд бий болсон нь Төв азийн овог аймгуудын нийгэм-эдийн засгийн хөгжлийг эрс хурдасгажээ. Хүрлийн үед холбогдох буган хөшөө, дөрвөлжин булш, нүсэр том хиригсүүрүүд, дагалдах олон байгууламжууд, ёслолын хэдэн арван цагираг зэрэг нүсэр байгууламжуудыг овог, аймгийн сурвалжитнууд, цэргийн жанжин нарын дурсгалд зориулан байгуулдаг байсан нь нүүдэлчдийн нийгмийн хөгжлийн түвшин нэлээд боловсронгуй байсныг илтгэн харуулж байна.

Харин нүүдэлчдийн байлдааны зэвсэг, бамбай, дуулга зэрэг хамгаалах өмсгөл, хүнд, хөнгөн морин цэргийн төрөл буй болсон зэрэг нь нүүдэлчдийн цэрэг армийн хөгжлийн түвшинг илтгэнэ.

Хятадын эртний улсуудтай нүүдэлчин аймгууд эрт үеэс харилцаатай байж, зарим үед урт удаан үргэлжилсэн дайн хийж байсан зэрэг Хятад сурвалжууд дахь баримтууд нь Төв Азийн эртний нүүдэлчид нэлээд хүчирхэг, зохион байгуулалт сайтай байсныг харуулдаг.

Түүнчлэн археологи, антропологийн сүүлийн үеийн судалгаанаас үзэхэд хүрэл, төмрийн түрүү үед монголын баруун болон төв хэсэгт хиригсүүрийн соёлт овог аймгууд, нутгийн Төв болон зүүн хэсэгт дөрвөлжин булшны соёлт аймгууд төвлөрөн иргэншиж байснаас үзэхэд монгол нутагт наанадаж МЭӨ II мянганы дунд үеэс хоёр соёл иргэншил, угсаа-гарал бүхий овог аймгууд зэрэгцэн оршиж байсныг харуулж байна. II мянганы дунд үе гэхэд Төв Азид угсаа-соёлын бүслэл нэгэнт тогтсон байв. Иймээс наанадаж МЭӨ III мянганы сүүлчээр нүүдлийн мал аж ахуй үүссэн гэж үзэж болохоор байна. Учир нь нүүдлийн мал аж ахуй үүссэнээр түүнд суурилсан нүүдлийн соёл иргэншил үүсэн, улмаар Төв азийн нүүдэлчдийн дунд угсаа-соёлын бүслэл тогтсон хэмээн бид үзэж байна.

МЭӨ II мянганы дунд үеэс Монгол нутагт оршин байсан нүүдэлчдийн дунд угсаа-соёлын бүслэл тогтож, баруун болон төв монголд хиригсүүрийн соёлт овог аймгууд, төв болон дорнод монголд дөрвөлжин булшны соёлт овог аймгууд зэрэгцэн оршиж, улмаар миграцийн улмаас холилдон бие биедээ аж ахуй, соёл, хүн ам зүйн хувьд уусан угсаатан бүрэлдэх үйл явцад ихээхэн нөлөө үзүүлжээ.

The formation of Central Asian nomadic ethno-cultural belt.

By P. Delgerjargal.

Summary

The up-to-date archeological, anthropological studies illustrated that from prehistoric times in Western and Mongolia cultivated the "hirgisur" rituals. Also the "square" tombs cultivated in the Eastern parts of Mongolia. The two cultures belong to the particular ethnical groups were inhabited in Mongolia at least 2000. The Central Asian cultural belt has already been formed in second millennium. Therefore We conclude that it is obvious that the nomadic civilization based on livestock breeding formed at least in the III millennium BC.

Ишлэл, зүүлт

1. Волков В.В. Бронзовый и ранний железный век северной Монголии. УБ., 1967
2. Дорж Д. Неолит восточной Монголии. УБ., 1971
3. Дорж Д, Новогодова Э.А. Петроглифы Монголии. УБ., 1975
4. Дэлгэржаргал П. Монгол нутагт төр төстэй бүрдэл үүссэн түүхийн асуудалд– Монголын төр эрх зүйн түүхийн зарим асуудал. УБ., 2001
5. Монголын түүхийн хураангуй хэрэглүүн. I дэвтэр. УБ., 1992
6. Наваан Д. Дорно Монголын хүрлийн үе. УБ., 1975
7. Сэр-Оджав Н. Монголын эртний түүх. УБ., 1977
8. Түмэн Д. Монголын эртний нүүдэлчдийн гарал үүслийг антропологийн үүднээс тайлбарлах нь-Төв азийн соёл иргэншлийн зарим асуудал. УБ., 2001
9. Түмэн Д. К антропологии западной Монголии. Археологийн судлал. Tom VII, Fasc 5, УБ., 1977
10. Түмэн Д., ба бусад. Монголын Хүннүгийн антропологи. МУИС-ын ЭШБ. Археологи, антропологи, угсаатан судлал. УБ., 2002. №187/13/
11. Цэвээндорж Д., Баяр Д ба бусад. Монголын археологи. УБ., 2000
12. Цэвээндорж Д. Монголын эртний урлагийн дурсгал. УБ., 1998
13. Эрдэнэбаатар Д. Монгол нутгийн дөрвөлжин булш, хиригсүүрийн соёл. УБ., 2002.